

БАТЛАВ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД УЛСЫН
УРГАЦЫН КОМИССЫН ДАРГА

Handwritten signature

ЧУЛААН

2019.09.02

**УРГАЦ ХУРААЛТЫН ҮЕД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019.09.02

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах гишүүн	Хугацаа
1	Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, аж ахуйн нэгж, айл өрх, иргэдийн хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний борлуулалтыг гарал үүслийн гэрчилгээтэй болгох, хураалтын мэдээг үнэн зөв шуурхай гаргаж улсын нэгдсэн мэдээ тайланд тусгуулах,	Аймаг, нийслэл, сумын засаг дарга нар,	YIII/30- XI/15
2	Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажилд шаардагдах шатахууны нөөцийг бүрдүүлэх, саадгүй хангах арга хэмжээг зохион байгуулах, цахилгаан эрчим хүчээр тасралтгүй найдвартай хангах, ургацын ажлын дундуур өр авлага, төлбөр тооцоо хийж эрчим хүчний хязгаарлалт хийхгүй байх зохицуулалтын арга хэмжээ авч ажиллах,	Эрчим хүчний дэд сайд, УУК-ийн гишүүн Т.Гантулга, Ашигт малмал, газрын тосны газрын дарга, УУК-ийн гишүүн Х.Хэрлэн нар,	YIII/30- XI/20
3	Үер ус ихтэй байсан энэ жилийн онцлогийг харгалзан ургац тээвэрт ашиглагдах зам гүүрийн эвдрэл гэмтлийг шалгаж тодруулах, шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж эх үүсвэрийг нь шийдвэрлүүлэн засварын ажлыг шуурхайлах,	Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, УУК-ийн гишүүн Л.Халтар, Сангийн дэд сайд, УУК-ийн гишүүн Х.Булгантуяа, Аймаг, нийслэлийн Засаг дарга нар,	YIII/30- IX/15
4	Авто болон төмөр замын ургац тээврийн хэрэгслэлүүдийн бэлэн байдлыг хангах, саатал гаргахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээ авах, ургац тээвэрлэлтэд ажиллах тээврийн хэрэгслэлийн сонгон шалгаруулалтыг шуурхайлж гэрээ байгуулах,	Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, УУК-ийн гишүүн Л.Халтар, ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, УУК-ийн гишүүн В.Үнэнбат,	YIII/30- IX/15
5	Сортын хянан баталгааг хугацаанд нь хийж дуусгах, дараа оны тариалалтад зориулан нөөцлөх үрийн цэвэрлэгээг	МХЕГ-ын дарга, УУК-ийн гишүүн Н.Цагаанхүү, ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга	IX/5-XI/15

	шалгаж стандартад тэнцүүлэх, ногооны зоорь, агуулах, үтрэмийн цэвэрлэгээ ариутгал, бүтээгдэхүүний хадгалалтад хяналт тавьж ажиллах,	Ц.Болорчулуун, Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга нар,	
6	Буудай хадгалах агуулах, элеваторуудын засвар үйлчилгээг хийж хатаалгын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, намрын ургацаас чанар сайтай үрийн болон хүнсний буудайн нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах,	ОБЕГ-ын дарга, УУК-ийн гишүүн Т.Бадрал, ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, МХЕГ-ын дарга, УУК-ийн гишүүн Н.Цагаанхүү, ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, УУК-ийн гишүүн В.Үнэнбат, Монголын тариаланчдын үндэсний холбооны дэд тэргүүн, УУК-ийн гишүүн Ц.Рэнчинсэнгээ, Гурилын үйлдвэрүүдийн захирлууд,	ҮИИ/30- XI/15
7	Үрийн болон хүнсний улаанбуудайн өртгийн тооцоог үндэслэлтэй гаргаж үнэ тогтоох явцыг хянаж баталгаажуулах,	ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, УУК-ийн гишүүн В.Үнэнбат, МТҮХ дэд тэргүүн, УУК-ийн гишүүн Ц.Рэнчинсэнгээ,	ҮИИ/30- X/15
8	Ургац хураалтын үед ашиглагдах жин хэмжүүр, хэмжих хэрэгслэлийн баталгаажуулалтыг яаралтай хийж дуусган ургац хүлээн авахад бэлэн болгох,	Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга УУК-ийн гишүүн Б.Билгүүн, ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, УУК-ийн гишүүн В.Үнэнбат, Аймаг, нийслэлийн Хүнс ,хөдөө аж ахуйн газрын дарга нар, Гурилын үйлдвэрүүдийн захирлууд,	ҮИИ/30- IX/10
9	Ургац хураалтын явцад тариаланчдыг цаг агаарын урьдчилсан мэдээ, мэдээллээр тогтмол хангах, мэдээллийг түгээх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх,	Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга, УУК-ийн гишүүн С.Энхтүвшин, аймаг нийслэлийн Хүнс ,хөдөө аж ахуйн газрын дарга нар,	ҮИИ/30- XI/01
10	Таримлын болц, цаг агаарын төлөв байдалтай уялдуулан боловсруулсан ургац хураалтын үед баримтлах технологийн ерөнхий зөвлөмжийг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан тариаланчдын хүртээл болгох арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх,	ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн захирал, УУК-ийн гишүүн Н.Баярсүх,	ҮИИ/30- IX/30

11	Ногоон тэжээлийн стандартыг боловсруулж батлуулах,	ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн захирал, УУК-ийн гишүүн Н.Баярсүх, Стандартчилал, хэмжил зүйн газрын дарга УУК-ийн гишүүн Б.Билгүүн,	ҮИИ/30-IX/03
12	Ургац хураалтын ажилд оюутан, сурагчид, цэргийн албан хаагчид, ажилгүй иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулах, өртөг зардлыг бодитой гаргаж тохиролцон гэрээний нөхцлийг сайжруулах, тэдгээрийн эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангаж ажиллах,	ХХААХҮ-ийн дэд сайд, УУК-ийн гишүүн Ж.Сауле, БХ-ын дэд сайд, УУК-ийн гишүүн Т.Дуламдорж, БСШУС-ын дэд сайд, УУК-ийн гишүүн Ганбаяр, ХНХ-ын дэд сайд УУК-ийн гишүүн С.Мөнгөнчимэг, ЭМ-ийн дэд сайд УУК-ийн гишүүн Л.Бямбасүрэн, Аймаг, нийслэлийн засаг дарга нар, аж ахуйн нэгжийн удирдлагууд,	IX/5-X/20
13	Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн ажилд оролцож буй тариаланчид, ногоочид, оюутан сурагчид, цэргийн алба хаагчдад зориулсан эрүүл мэндийн үйлчилгээг газар дээр нь үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх,	ЭМ-ийн дэд сайд УУК-ийн гишүүн Л.Бямбасүрэн, Аймаг, нийслэл, сумдын засаг дарга нар,	IX/5-X/20
14	Ургац хураалтын ажлын явц болон үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр шуурхай дамжуулж олон нийтэд хүргэх, тариалангийн салбарт авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг сурталчилах чиглэлээр хамтран ажиллах,	Монголын Үндэсний олон нийтийн радио, телевизийн захирал, УУК-ийн гишүүн Л.Нинжжамц, ХХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун,	ҮИИ/30-XI/25
15	Үр тариа, төмс, хүнсний ногооны тээврийг нийслэл болон томоохон хотуудын борлуулалт, хадгалалтын цэгүүдэд саадгүй нэвтрүүлэх, улсын чанартай зам, гүүрэн дээр цагдаагийн эргүүл, пост ажиллуулах,	Цагдаагийн ерөнхий газрын Замын цагдаагийн албаны дарга, УУК-ийн гишүүн Д.Амарсайхан, ХХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун,	ҮИИ/30-XI/15
16	Төмс, хүнсний ногооны борлуулалтыг дэмжих, иргэдийг хямд үнэтэй, чанартай ногоогоор хангах зорилгоор хотын дүүргүүдэд төмс, хүнсний ногооны борлуулалтын цэг нэмж	Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга, УУК-ийн гишүүн Н.Гантөмөр, ХХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын	ҮИИ/30-XI/01

	ажиллуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх,	дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, Хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбооны гүйцэтгэх захирал УУК-ийн гишүүн Т.Төрмандах нар,	
17	ОХУ-аас нийлүүлэгдэх комбайны хуваарилалтыг аж ахуйн нэгж, иргэнээр хийж батлуулан гэрээ байгуулах, урьдчилгаа төлбөр, гааль татварыг шийдвэрлэж шуурхай борлуулах,	ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун, ТЭДС-ийн гүйцэтгэх захирал, УУК-ийн гишүүн В.Үнэнбат,	ҮИИ/30- ХI/15
18	Ургацыг мал амьтанаас хамгаалах ажлыг орон нутагт үр дүнтэй зохион байгуулах, хашаажуулалтын ажлын явцыг эрчимжүүлэх,	Аймаг, нийслэл, сумын засаг дарга нар, тариалан бүхий аж ахуйн нэгжийн удирдлагууд, ХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун,	ҮИИ/30- ХI/15
19	Ургац хураалтын үед ажиллах “Ургацын төв штаб” –ын үйл ажиллагааг тогтмолжуулж орон нутгаас тавьсан санал хүсэлтийг хүлээн авч шуурхай шийдвэрлүүлж уялдуулан зохицуулж ажиллах,	ХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун,	ҮИИ/30- ХI/15
20	Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж танилцуулах,	ХААХҮЯ-ны ГТХБЗГ-ын дарга, УУК-ийн нарийн бичгийн дарга Ц.Болорчулуун,	ХI/25

УЛСЫН УРГАЦЫН КОМИСС